

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Г “Жавхлант Алдархаан ББСБ” ХХК-д 7
гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жавхлант Алдархаан ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримт бичгийг 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жавхлант Алдархаан ББСБ” ХХК /А.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН